



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1993 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 7-258

Улаанбаатар хот

Жаргалант дүүргийн төвийн 800
үнээний саалийн механикжсан фер-
мийн талаар авах арга хэмжээ-
ний тухай

1. Жаргалант дүүргийн төвийн 800 үнээний саалийн механикжсан фермийг 1993 оны 12 дугаар сарын 6-наас "Дэлгэрэх" улсын үйлдвэрийн газар /УҮГ/ болгосугай.

2. "Дэлгэрэх" УҮГ-т хөдөлмөр зохион байгуулалт, өмч хөрөнгийн ашиглалт, дэг журам, технологийн горим, хорио цээрийн дэглэмийг шаардлагын түвшинд хүргэж, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах ажлыг удирдан зохион байгуулах комиссыг I дүгээр, авах арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Комисст даалгах нь:

а/ "Дэлгэрэх" УҮГ-ын хэвийн ажиллагааг хангах ажлыг нарийн график гарган ажиллаж 12 дугаар сарын 20-ны дотор дуусгах.

б/ Энэ ажилд холбогдох байгууллагуудын хүчийг дайчлан оролцуулах.

в/ Боловсон хүчний асуудлыг судлаж шийдвэрлэх.

4. Энэ захирамж, арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /н.Болдсайхан/-т даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА

Ц.БААСАНЖАВ